



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2019 оны 04 сарын 05 өдөр

Дугаар А/192

Булган

Мал эмнэлгийн ариун цэврийн сарын ажлыг зохион байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3-ын "а", Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, 7 дугаар зүйлийн 7.3.3, 7.3.4 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн хэмжээнд мал эмнэлэг, ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлагыг хангах, үхэж хорогдсон мал, амьтны сэг, зэмийг устгах, бэлчээр, хашаа хороо, өвөлжөө, хаваржаа болон худаг, уст цэгийн орчныг цэвэрлэж, ариутгал халдваргүйжүүлэлт хийх ажлыг 2019 оны 04 дүгээр сарын 15-наас 05 дугаар сарын 15 хүртэлх хугацаанд зохион байгуулсугай.

2. Сарын ажлыг зохион байгуулахад сумдын Мал эмнэлгийн тасаг, нэгжүүдийг мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Мал эмнэлгийн газар /Л.Галбадрах/, хүн хүч, машин техник, бусад шаардлагатай зүйлээр хангаж ажиллахыг сумын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

3. Зохион байгуулсан ажлын хэрэгжилт, явцад хяналт тавьж, дүнг нэгтгэн 2019 оны 06 сарын 01-ний дотор аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулахыг Мэргэжлийн хяналтын газар /Б.Батболд/-г даалгасугай.

ЗАСАГ ДАРГА  З.БАТЗОРИГ

